

## СУРАЛЦАГЧИЙН ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ХИЧЭЭЛД ХАНДАХ ХАНДЛАГЫГ ИЛРҮҮЛЭХ НЬ

*О.Болор, доктор, Д.Булгантуяа, Э.Батчимэг, магистр, МУБИС*

### Abstract

The paper aims to explore how children's interest, motivation, and attitudes towards learning has been gradually decreased even though they have more opportunities to see and learn with the help of technology in the modern information society. People tend to understand that drawing is naturally inherited talent, however, some scholars consider that 1% is natural talent while 99% depends on one's frequent efforts.

The main focus of this study is to analyze Fine Arts students' artistic senses, their talents in arts, and attitudes towards Fine Arts based on the objective data taken from the students who are earning their degrees in Fine Arts Education. We tried to clarify the learners' attitudes towards fine arts, so the data were taken from 100 high school students from high schools, 171 BA students majoring in Preschool and Primary Education and Fine Arts Education at Mongolian National University of Education. The results of the study show that the Preschool and Primary Education students' interest in arts was 50.4%, while Fine Arts students' attitudes towards arts was 85.3%. This simply tells that it seems possible to develop their artistic senses and skills if those Preschool and Primary Education students work hard and try to take their interest in fine arts.

### Түлхүүр үг

Дүрслэх урлаг хандах хандлага, нөлөөлөх хүчин зүйл, авьяас, сонирхол

### Удиртгал

Америкийн сэтгэл зүйч А.Маслоугийн онолд өөрийгөө идэвхжүүлэхүйн хэрэгцээ бол хүний суурь хэрэгцээ нь хангагдсаны дараа л илрэх боломжтой хэмээжээ. Өөрийгөө идэвхжүүлэх нь хүн дахин давтагдашгүй дотоод далд байгаа нөөц бололцоогоо илрүүлэх явдал юм. А.Маслоугийн онолын үндсэн гол ойлголт нь өөрийгөө нээх, идэвхжүүлэх бөгөөд энэ нь өөрийн боломж, авьяас чадварыг бүрэн дүүрэн ашиглах гэсэн утгыг илэрхийлж байдаг (Батдэлгэр, 2013, х. 81-82). Бидний судалгаа нь хүнд янз бүрийн хэрэгцээ байдаг, хүн анхдагч хэрэгцээгээ нөхөж байж дараагийн шатны хэрэгцээгээ хангаж байдаг гэсэн онол дээр тулгуурласан юм. Сурах үйлийг хувь хүний мэдлэг, чадвар дадал, соёлын үнэт зүйлсийг эзэмших, шинэ хандлагаар төлөвших үйл явц гэж ерөнхий байдлаар тодорхойлж болох юм. Харин суралцах гэсэн ухагдахууныг идэвхтэй сурах үйл гэсэн илүү өргөн утгаар авч үздэг. Дадал чадварыг эзэмших нь сурах үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг билээ. СХУ, сэтгэл судлалд чадварын тухай ойлголтоос үзвэл, чадвар нь арга барилын бүрэлдэхүүнд тогтсон үйлдлүүдийн систем юм (Сувд, 2010, х. 36).

“Өөрөө хөгжье, өөрийгөө хөгжүүлье” гэсэн хандлага Самуэл Смайлын 1858 онд хэвлүүлсэн “Өөртөө туслах ухаан” номд “Бурхан гагцхүү өөрөө өөртөө тусалдаг хүнд л тусалдаг” хэмээх зүйр үг асар их зам туулж үе үеийг дамжиж өнөөг хүрсэн гэдгийг мартаж болохгүй. Бид суралцагчдын өөртөө туслах ухааныг нь дэмжье

гэвэл сургах үйлд биш, харин бие даан суралцах үйлийг дэмжихэд гол анхаарлаа хандуулах нь зүйтэй. Энэ цагийн хүүхдийн хандлага, хүсэл зорилго, үнэт зүйл, сэтгэхүй нь өмнөх нийгмийнхээс эрс ялгаатай болсонд хэргийн гол учир шалтгаан оршиж буй юм. Багш нар хүүхдийн дарга мэт сэтгэхүй, арга барил ноёрхож байлаа. Угтаа хичээл бол багш, суралцагчийн хамтын харилцан үйлдэл, интерактив үйл хэрэг юм. Тийнхүү хамтын хөдөлмөр, хамтын үр дүн учраас бас хамтын хариуцлага юм. Суралцагчаа шахаад бүр бухимдаад ч, төдий л үр дүнд хүрэхгүй харин хэрхэн хамтран ажиллах вэ? гэдэгт ухаанаа зарах хэрэгтэй болоод байна. (Пүрэвдорж, 2014, х. 23)

Хүний оюун ухаан нь бие даасан тусгай чадамжуудаас бүтдэг цогцолбор зүйл хэмээн Америкийн сэтгэл зүйч Х. Гарднер үздэг. Оюун ухаан гэдэг нь бие даасан долоон өөр чадамжийг агуулдаг (Мягмар, 2010, х. 20).

Үүнд:

1. Хэл ярианы оюун ухаан
2. Хөгжмийн оюун ухаан
3. Математик логикийн оюун ухаан
4. Орон зайн оюун ухаан
5. Биеийн хөдөлгөөн тэнцвэрийн оюун ухаан
6. Хүмүүс хоорондын харилцааны оюун ухаан
7. Өөр лүүгээ, дотогш чиглэсэн оюун ухаан

Хувь хүний дүрслэх үйлийг бага наснаас нь зөв чиглүүлэх ямар шаардлага байгааг “Хүн

оюуны хөгжлийнхөө ерөнхий чадварын 50% -ийг 0-4 насанд, 30%-ийг 5-8 насанд, 20%-ийг 8-20 насандаа олж төлөвшдөг” гэдгээр тодорхойлж болно. (Нандинцэцэг, 2014, х.100-101)

Ж. Пиаже “Хүний биологийн бүтцийн хувьд орчиндоо дасан зохицох үйл явц нь хүний уураг тархинд явагдаж буй сэтгэхүйн үйл ажиллагааны хэлбэрүүдтэй адил байдаг” гэж үзээд орчиндоо дасан зохицох үйл явц ассимиляц, аккомодаци гэсэн хэлбэрээр явагдана. Үүнд: Хүн орчныхоо нөлөөллийг өөртөө байгаа боломжийн хэрээр хувирган зохицдог бөгөөд түүнийг “Ассимиляц” гэдэг. Түүнтэй адил хүн мэдээллийг хүлээн авахдаа өөртөө байгаа хур мэдлэгийн хэмжээгээр мэдээллийг өөртөө зохицуулан боловсруулдаг байна. Тэгвэл үүний нөгөө талд хүн өөрөө өөрчлөгдөж орчиндоо дасан зохицдог “Аккомадац” байдгийн адил өөрийнхөө өмнөх мэдлэгийн бүтцэд өөрчлөлт хийж шинэ мэдлэг олж авдаг гэсэн тун энгийн боловч сургалтын үйл ажиллагааны явц болоод үр дүнд нөлөөлдөг чухал ойлголт байдаг. Түүнчлэн эдгээртэй яв цав уялдах конструктивист хандлагын амин сүнс болсон нэгэн ухалдахуунд томъёолол бол хүн мэдлэгийг бусдаас дамжуулан хүртдэггүй харин өөрөө өөртөө зохиомжлон бүтээдэг гэсэн ойлголт юм. Эдгээр ойлголтууд нь сурагчдын дүрслэн урлах үйлийн баримжааг хөгжүүлэх үндэс юм.

### Судалгааны арга зүй

12-р ангийн сурагчид, багш бэлтгэх сургуулийн 1, 2 курсийн оюутан суралцагчдаас дүрслэх урлагийн сонирхол, мэргэжлээс хамаарсан хандлагыг тандан илрүүлэхийг зорилоо.

#### Зорилт

1. ЕБС-ийн 12-р ангийн суралцагчдын дүрслэх урлагийн хичээлд сонирхох сонирхлыг илрүүлэх судалгааг асуулгын аргаар судлах
2. МУБИС-ийн Багшийн сургууль, Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Дүрслэх урлагийн сургуулийн 1, 2-р курсийн оюутан суралцагчдын дүрслэх урлагийн хичээлд хандах хандлагыг илрүүлэх судалгааг асуулгын аргаар судлах, дүн шинжилгээ хийх

#### Хамрах хүрээ

Судалгаа-1: Ерөнхий Боловсролын Сургуулийн 12-р ангийн 100 сурагчид:

- БГД-ийн Монгени цогцолбор сургуулийн 12-р ангийн 20 сурагч
- СБД-ийн 1 сургуулийн 12-р ангийн 26 сурагч
- СБД-ийн Зохион бүтээх Ахлах сургуулийн 12-р ангийн 31 сурагч

- СХД-ийн 9-р сургуулийн 12-р ангийн 23 сурагч

Судалгаа-2: МУБИС-ийн 1, 2 курсийн нийт 171 оюутан:

- Багшийн сургуулийн 2-р курсийн 61 оюутан
- Сургуулийн Өмнөх Боловсролын Сургуулийн эчнээ 2-р курсийн 50 оюутан
- УБТС-ийн Дүрслэх Урлаг Технологи, Дүрслэх Урлаг Дизайн, Дизайн Компьютер График, Технологийн 1-р курсийн 60 оюутан

Судалгааны арга:

- Асуулга
- Баримт материалд дүн шинжилгээ хийх

### Үр дүн

Оюутан сурагчдын дүрслэх урлагийн сонирхлыг илрүүлэх 3 чиглэлээр 15 асуулга боловсруулж, судалгааг авлаа. Судалгааны үр дүнг графикаар харуулбал (Зураг 1-6 харна уу.)

Зураг 1


Зураг зурах сонирхол



Судалгаанд хамрагдагсдын дийлэнх буюу 32%-42% нь сонирхолтой гэж хариулсан нь дүрслэх урлагт аль ч насны хүн сонирхолтой байдаг. Мэргэжлээс хамааран улам идэвхэждэг болох нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Зураг 2


Сурагчдын сонирхолд нөлөөлсөн хүчин зүйлс



Дүрслэх урлагт сонирхолтой болоход “Багш” нөлөөлдөг гэж Багшийн сургуулийн оюутнуудын 78.6%, СӨБС-ийн оюутнуудын 50%, дүрслэх урлагийн сургуулийн 1-р курсийн

оюутнуудын 30% нь багш нөлөөлсөн гэжээ. Багш мэргэжлийг сонгон суралцаж байгаа 1-р курсийн оюутан суралцагчдад мэргэжлийн онцлог чиг баримжаа олгох заах арга зүйн хичээлүүд түлхүү орж байгаатай холбоотой. Нөгөөтэйгүүр цэцэрлэгийн багш, бага ангийн багш, дүрслэх урлагийн мэргэжлийн хичээл зааж байгаа багш нар үндсэн сургалтаас гадна нэмэлт сургалтаар оюутныг хөгжүүлэх дугуйлан, клубээр дамжуулан ганцаарчлан ажилладагтай холбоотой.


**Зураг 3**  
Гүнзгийрүүлсэн сургалтад хамрагдсан байдал



Дүрслэх урлагаар гүнзгийрүүлэн суралцаж байсан гэсэн хариултыг Дүрслэх урлагийн оюутнуудын 26.6%, 12-р ангийн сурагчдын 24%-ийг эзэлж байгаа нь 12 жилийн сургууль болон мэргэжлийн сургуулийн гүнзгийрүүлэх сургалтад тодорхой хэмжээгээр хамрагддаг болох нь харагдаж байна. Ерөнхий боловсролын сургуульд дүрслэх урлагаар гүнзгийрүүлэн суралцаж байсан хүүхдүүд сонирхлоо дагаад мэргэжлийн сургуульд ур чадварын шалгалт өгч орж ирдэгтэй холбоотой.

Харин СӨБС-ийн оюутны 90%, Багшийн сургуулийн 88% нь дүрслэх урлагаар гүнзгийрүүлэн судлалцаж байгаагүй гэсэн хариулт харьцангуй өндөр байгаа нь хувь хүний сонирхол, мэргэжил сонголттой холбон тайлбарлаж болно.

**Зураг 4**  
Дүрслэх урлагийн хэрэгцээ




Хэрэгцээтэй гэж СӨБСургууль 94%, Багшийн сургууль 75%-ийн өндөр үзүүлэлттэй байгаа нь 1, 2-р курсийн оюутнууд суралцах хугацаандаа мэргэжлийн чиг хандлагаа ойлгож эхэлсэн, мэргэжлээс хамаарсан сонирхол үүсэн бий болсонтой холбоотой.

Судалгаанд 12-р ангийн сурагчдын 33% нь дүрслэх

урлагийн хичээл хэрэгцээгүй гэсэн хариултаас үзэхэд ЕБС-ийн дүрслэх урлагийн боловсролын чанартай холбоотой.

**Зураг 5**


Дүрслэх урлагт сонирхолтой болоход нөлөөлөх хүчин зүйл



Дүрслэх урлагийн сургуулийн 1-р курсийн 60 оюутнаас ”Суралцагчдын дүрслэх урлагийн сонирхолд нөлөөлөх хүчин зүйл”-ийг тодруулахад хувь хүний хичээл зүтгэлгэж 81.6%, чадвар гэж 71.6%, авьяас гэж 70% хариулсан нь сонирхлоороо мэргэшүүлэн суралцаж байгаа оюутнуудын хувьд энэ мэргэжлийнхээ зорилго чиглэлийг ойлгосон байна.

**Зураг 6**

Дүрслэх урлагийн мэргэжлийн сургуулийн 1-р курсийн оюутан суралцагчдын дүрслэх урлагийн төрлийг сонгосон байдал



Дүрслэх урлагийн мэргэжлийн сургуулийн 1-р курсийн оюутан суралцагчдын 68.3% нь уран зураг, ардын гар урлал 36.6%, зураасан зураг 5%, уран барилгыг 3.3 % нь сонирхдог гэж хариулсан ба харин уран баримлыг сонгоогүй байна. ЕБС-ийн дүрслэх урлагийн хичээлийн сургалтын хөтөлбөр, сурах бичигт нь баримлын төрөл тусгагдсан хэдий ч цаашлаад дүрслэх урлагийн багш нар нь төдийлөн чанартай ордоггүйтэй холбоотой энэхүү үзүүлэлт гарсан болов уу гэж дүгнэж байна. МУБИС-ийн Урлаг Биеийн Тамирын сургууль 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн Дүрслэх урлагийн тэнхим дээр уран баримал, керамикийн кабинетийг тохижуулан сургалтын төлөвлөгөөнд тусган хичээлийг гүнзгийрүүлэн зааж эхэлсэн нь элсэн суралцагчдад уран баримал керамикийн төрлөөр мэргэшихэд дөхөмтэй болсон.

**Судалгааны үр дүн**

1. ЕБС-ийн 12-р ангийн сурагчдын дүрслэх урлагийн сонирхол нь 32%-тай байхад сурагчдын сонирхолд нөлөөлсөн хүчин зүйлд бусад 30%, харин багш 17% нөлөөлж байгаа нь харьцангуй доогуур үзүүлэлт юм. Энэ нь ЕБС-ийн I-V ангид дүрслэх урлагийн хичээлийг бага ангийн багш зааж байгаа нь сургалтын чанар, цаашлаад суралцагчдын дүрслэх урлагийн хичээлд сонирхох сонирхлыг бууруулж, ур чадварт нь сөргөөр нөлөөлж байна. Иймээс бага ангийн дүрслэх урлагийн хичээлийг мэргэжлийн багшаар заалгах шаардлагатай байна.
2. СӨБ болон багш бэлтгэх сургуулийн оюутан суралцагчдын дүрслэх урлагийн сонирхол харилцан адилгүй байгаа нь судалгаанаас харагдлаа. Учир нь багш бэлтгэх сургуульд мэргэжлийн сонголт хийж элссэнтэй холбоотой. Сурагчдын дүрслэх урлагийн сонирхолд нөлөөлсөн хүчин зүйлсээс “багш” хамгийн чухал нөлөөтэй байгаа нь цаашид дүрслэх урлагийн багшийн мэдлэг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх шаардлага байгааг харуулж байна.
3. Дүрслэх урлагийн сургуулийн 1, 2-р курсийн оюутнуудаас дүрслэх урлагт сонирхолтой болоход нөлөөлөх хүчин зүйлээс хичээл зүтгэл 81.6%, чадвар 71.6%, авьяас 70% гэсэн хариулт өндөр байгаа нь мэргэжлийн чиг хандлагатай холбоотой бөгөөд 68.3% уран зургийг сонгосон нь уран зургийг сонирхох оюутнууд их байгааг харуулж байна. Дүрслэх урлагт сонирхолтой болоход нөлөөлөх хүчин зүйлээс хичээл зүтгэл 81.6% байгаа нь оюутан авьяасгүй ч гэсэн сонирхол, хичээл зүтгэл байхад өөрийгөө хөгжүүлэх бүрэн боломжтой гэдгийг харуулж байна.

### Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. МУБИС-ийн мэргэжлийн ангиудад элсэн суралцагчдыг өндөр оноогоор нь жагсаахаас илүүтэй сонирхол, ур чадварт тулгуурлан элсүүлж байвал мэргэжлийн хичээл заадаг багш нарт дөхөмтэй, цаашлаад сургалтын чанар дээшилнэ.
2. Багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэлээр мэргэжлийн дидактик хичээлийн эзлэх хувь бага, кредит цөөрч байгаа нь цэцэрлэг, бага ангийн багш болох суралцагчдын

мэргэжлийн мэдлэг, ур чадвар буурах хандлага харагдаж байна.

Энэ бүхнээс дүгнэн үзвэл цаашид сургалтын хөтөлбөртөө дүрслэх урлаг, дүрслэх урлаг-дидактикийн хичээлийн кредит цагийг нэмэгдүүлэх, оюутны ур чадварыг хөгжүүлэх асуудал урган гарч байна.

3. Мэргэжлийн ангийн оюутан суралцагчдаас авсан санал асуулгын үр дүнгээс Урлаг Биеийн Тамирын Сургуулийн Дүрслэх урлагийн тэнхимд “Уран зураг”, “Баримал керамик”-ийн чиглэлээр шинээр анги нээх боломжтой гэж үзлээ.

### Ашигласан материал

- Батдэлгэр, Ж. (2013). *Бага насны хүүхдийн сэтгэл судлал*. Улаанбаатар: ВСИ
- Баярцэцэг, Б., Лхагвасүрэн, Г. (2005). Боловсролын хүрээлэн, “ЕБС-н сурагчдын төлөвшил ба боловсролын зорилго” Улаанбаатар. Best printing company
- Нандинцэцэг, Ё. (эмх), (2014). *Тогтолцооны хандлага ба боловсролын судалгаа*. Улаанбаатар: Битпресс
- Мягмар, О. (2010). *Сэтгэл судлал*. Улаанбаатар: Ганпринт
- Өсвөр үеийн хөгжлийн төв. (2004-2005). судалгааны тайлан. Улаанбаатар
- Пүрэвдорж, Ч. (2014). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар, Мөнхийн үсэг
- Сувд, Ч. (эмх). (2010). *Оюуны хөтөч*. Улаанбаатар: МУБИС
- Цэцэгжаргал, Х., Баярмаа, Б. (2014). Боловсролын хүрээлэн, “ЕБС-ийн сургалтын орчны бодлого зохицуулалт ба хэрэгжилтийн өнөөгийн байдал”. Улаанбаатар: Best printing company
- UNICEF. (2014). *Суралцагчдын мэдлэг чадварт хийсэн судалгаа*. Улаанбаатар